



Захиргааны нэг хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2021 оны 11 сарын 24-ны  
өдрийн 557 дугаарт бүртгэв.

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

“Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах  
радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”  
батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Радио  
долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2 дах заалтуудыг үндэслэн тус тус  
ТОГТООХ нь:

1. “Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

Т.НАРАНМАНДАХ

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн  
63 тоот тогтоолын  
хавсралт

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН АГААРЫН ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНД АШИГЛАХ  
РАДИО ДАВТАМЖИЙН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН  
НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэхүү баримт бичиг нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup> дах заалт, Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн багц дүрмийг тус тус үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэний нисэхийн радио холбоо, агаарын навигаци, ажиглалтын (цаашид "агаарын холбоо" гэх) үйлчилгээнд ашиглагдах радио давтамжийн зурвасыг төлөвлөх, хуваарилах, ашиглах болон радио станцуудын техникийн стандарт, ашиглалтын нөхцөл шаардлагатай холбогдох харилцааг тодорхойлно.

**ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР**

- 2.1 Энэхүү баримт бичигт MNS OIML D2: 2014 - "Хэмжлийн хуульчилсан нэгж", MNS 6478:2014 "Агаар ба газрын үйл ажиллагаанд хэрэглэх хэмжигдэхүүн болон нэгж", MNS 6409:2015 Иргэний нисэх "Ерөнхий нэр томъёо, тодорхойлолт", MNS6704:2018 "Иргэний нисэх. Нисэхийн хэт өндөр давтамжийн хөдөлгөөнт холбооны техникийн үзүүлэлт" стандартуудад тодорхойлогдсон нэр томъёог ашигласан.

**ГУРАВ. ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ**

- 3.1 Энэхүү баримт бичиг нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэсэн болно. Үүнд:
- 3.1.1 Харилцаа холбоо тухай хууль;
  - 3.1.2 Радио долгионы тухай хууль;
  - 3.1.3 Иргэний нисэхийн тухай хууль;
  - 3.1.4 "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт" /Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн газрын (цаашид ХХМТГ гэх) даргын 2020 оны А/80 дугаар тушаал/;
  - 3.1.5 "Радио давтамжийн хуваарилалтын дунд хугацааны төлөвлөлт (2020-2025)" /ХХМТГ-ын даргын 2020 оны А/149 дугаар тушаал/;
  - 3.1.6 "Радио давтамж ашиглах эрхийн бичиг олгох, түүний хугацааг сунгах, шилжүүлэх, хүчингүй болгох журам" /ХХМТГ-ын даргын 2020 оны А/46 дугаар тушаал/;
  - 3.1.7 Иргэний нисэхийн дүрэм - 171 "Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 02 сарын 04-ны А/16 тоот тушаалын 1 дүгээр хавсралт/
  - 3.1.8 Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн Хавсралт 10;

## **ДӨРӨВ. ҮНДЭСНИЙ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ**

- 4.1 Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид Зохицуулах хороо гэх) нь Дэлхийн радио холбооны дүрэм, Үндэсний радио давтамжийн төлөвлөлтийг үндэслэн агаарын холбооны үйлчилгээнд ашиглагдах радио давтамжийн зурвасын судалгааг Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-тай хамтран хийж, нөөцийг бүрдүүлэх ба иргэний нисэх болон агаарын холбооны тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл-шаардлагыг хамтран боловсруулж батална.
- 4.2 ИНЕГ нь агаарын холбооны чиглэлээр гаргасан Үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалт, зохицуулалтын баримт бичиг болон техникийн нормативын баримт бичгүүдийг мөрдөж, хэрэгжүүлнэ.
- 4.3 ИНЕГ нь агаарын холбооны үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх тохиолдолд Зохицуулах хороонд хандаж ашиглах радио давтамжийн зурвасыг харилцан тохирох ба шаардлагатай тохиолдолд Олон улсын радио давтамжийн мастер бүртгэлд бүртгүүлнэ.

### **ТАВ. РАДИО ДАВТАМЖИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, РАДИО СТАНЦАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

- 5.1 ИНЕГ нь агаарын холбооны үйлчилгээнд зориулж төлөвлөсөн радио давтамж, радио давтамжийн зурвасаас шаардлагатай зурвасыг Радио долгионы тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу Зохицуулах хорооноос радио давтамж ашиглах эрхийн бичиг авч үйл ажиллагаандаа ашиглана.
- 5.2 ИНЕГ-аас өөр бусад байгууллага энэхүү баримт бичгийн хавсралт 1-д тодорхойлогдсон радио давтамжийн зурвасыг ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд Зохицуулах хороо нь ИНЕГ-тай харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 5.3 ИНЕГ-аас бусад агаарын холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ХХМТГ-ын А/46 тушаалаар батлагдсан "Радио давтамж ашиглах эрхийн бичиг олгох, түүний хугацааг сунгах, шилжүүлэх, хүчингүй болгох журам"-д заагдсан баримт бичгээс гадна ИНЕГ-аас агаарын холбооны үйлчилгээ үзүүлэхийг дэмжсэн албан тоотыг заавал ирүүлнэ.
- 5.4 Иргэний нисэхийн агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч нь ОУИНБ (ИКАО) Чикагогийн Конвенцийн хавсралт 10 дах Боть I-ээс V-д, Монгол Улсын стандарт MNS6704:2018 болон Иргэний нисэхийн дүрэм-171 "Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт"-ийн шаардлагыг хангасан радио станцыг үйл ажиллагаандаа ашиглана.
- 5.5 ИНЕГ нь иргэний нисэхийн агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгчид олгох радио станцыг таних дуудлагыг Дэлхийн радио холбооны дүрмийн 1 дүгээр ботийн 5 дугаар бүлгийн 19.57 "Нисэх онгоцны станцууд"-ын дагуу олгоно.
- 5.6 Иргэний нисэхийн агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгчид нь MNS 5884:2020 "Холбооны цамхаг болон антены суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага"; MNS 6605:2016 "Үүрэн холбооны бааз станцуудын давтамж, орон зайн тусгаарлалт, илүүдэл цацаргалтын хэмжээ, хэмжих арга"-ыг хангаж ажиллана.
- 5.7 ИНЕГ нь дараа үеийн хөдөлгөөнт холбооны технологид тодорхойлогдсон хиймэл дагуулын Си (3400-4200 МГц) зурвасыг агаарын холбооны үйлчилгээнд ашиглах боломжгүй бөгөөд ашиглах шаардлагатай тохиолдолд Си зурвасын газрын станцын харилцан нөлөөллийн хамгаалалтын зайг ОУЦХБ-ын ITU-R F.2328 зөвлөмжид заагдсны дагуу тооцоолж байгуулах ба зөвшөөрөгдсөн радио давтамжийн зурваст тохируулж зурвасын шүүр заавал ашиглана.

## ЗУРГАА. ХЯНАЛТ БА ХАРИУЦЛАГА

- 6.1 Энэхүү баримт бичгийн хэрэгжилтэд Зохицуулах хороо болон харилцаа холбооны хяналтын улсын байцаагч, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нар холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.
- 6.2 Радио станц зөвшөөрөлгүй ашигласан, ашиглахаар байрлуулсан эсхүл энэхүү баримт бичгийг зөрчсөн этгээдэд Радио долгионы тухай, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.3 Агаарын холбооны үйлчилгээнд эрхийн бичгээр хуваарилагдсан радио давтамжийн зурваст харилцан нөлөөлөл илэрсэн тохиолдолд Зохицуулах хороонд албан хүсэлтийг энэхүү баримт бичгийн Хавсралт 2-т заасан мэдээллийн хамт илгээнэ. Шаардлагатай тохиолдолд албан бичгийг цахим шуудангаар цахим гарын үсгээр баталгаажуулж илгээж болно.
- 6.4 Зохицуулах хороо нь 6.3-т заасан албан хүсэлт, өргөдлийн маягтыг хүлээн авсан даруйд харилцан нөлөөлөл үүсгэж буй эх үүсвэрийг илрүүлэх, таслан зогсоох ажлыг шуурхай зохион байгуулна.
- 6.5 Агаарын холбооны үйлчилгээ эрхлэгчид нь Дэлхийн радио холбооны дүрмийн 1 дүгээр ботийн 15 дугаар дэд бүлэг "Радио давтамжийн харилцан нөлөөлөл"-ийн заалтуудыг ханган ажиллах ба 15.1 "Бүх радио станцууд шаардлагагүй дамжуулалт хийх, хэт хүчтэй дохио дамжуулах, хуурамч буюу төөрөгдүүлэх дохио дамжуулах, эсвэл таних боломжгүй дохио дамжуулахыг хориглоно." заалтыг дагаж мөрдөнө.
- 6.6 Хэрэв хөрш зэргэлдээ орнуудын агаарын холбооны үйлчилгээнээс Монгол Улсын агаарын холбооны үйлчилгээнд радио давтамжийн харилцан нөлөөлөл үүссэн тохиолдолд ИНЕГ нь тухайн орны иргэний нисэхийн удирдах байгууллагатай харилцан зөвшилцөж агаарын холбоонд ашиглах радио давтамжийн сувгаа зохицуулна.
- 6.7 Тус баримт бичгийн 6.6-д заасан үйлчилгээнээс бусад төрлийн үйлчилгээнээс Монгол Улсын агаарын холбооны үйлчилгээнд радио давтамжийн харилцан нөлөөлөл үүссэн тохиолдолд Зохицуулах хороо нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас баталсан Олон улсын радио холбооны дүрмийн дагуу радио давтамжийн харилцан нөлөөллийн асуудлыг хөрш зэргэлдээ орнуудын харилцаа холбооны удирдах байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 6.8 ИНЕГ нь радио давтамжийн харилцан нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Зохицуулах хорооны радио долгионы хяналтын техник төхөөрөмжүүдийг нийслэл болон орон нутгийн агаарын холбооны станцуудын байр, талбайд суурилуулж, хяналт шалгалт хийх боломжоор хангана.
- 6.9 Зохицуулах хороо нь радио давтамжийн харилцан нөлөөллийг илрүүлж, зөрчилтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсын Радио долгионы тухай хууль болон "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын хүрээнд холбогдох арга хэмжээг авч, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ИНЕГ-т албан бичгээр хүргүүлнэ.

## ДОЛОО. БУСАД

- 7.1 Энэхүү баримт бичигт техник, технологийн болон бодлогын шинэчлэлтэй холбоотойгоор тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

----- оОо -----

*“Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ын хавсралт-1*

**Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээний радио давтамжийн зурвасын хуваарилалт ба ашиглалт**

**Радио давтамжийн зурвас: 8.3-110 кГц**

<b>ОУЦХБ-ын хуваарилалт (Бүс I)</b>	<b>Үндэсний хуваарилалт</b>	<b>Ашиглалт</b>
<b>11.3-14</b> РАДИОНАВИГАЦИ	<b>11.3-14</b> РАДИОНАВИГАЦИ	Хэт урт долгионы давтамжинд ажиллах радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>84-86</b> РАДИОНАВИГАЦИ 5.60	<b>84-86</b> РАДИОНАВИГАЦИ	Урт долгионы давтамжинд ажиллах радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>90-110</b> РАДИОНАВИГАЦИ 5.62 Хөдөлгөөнт бүс 5.64	<b>90-110</b> РАДИОНАВИГАЦИ Хөдөлгөөнт бүс	Урт долгионы давтамжинд ажиллах радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.

**Радио давтамжийн зурвас: 110-255 кГц**

<b>110-112</b> ХӨДӨЛГӨӨНТ БУС ДАЛАЙН ХӨДӨЛГӨӨНТ РАДИОНАВИГАЦИ 5.64	<b>110-112</b> ХӨДӨЛГӨӨНТ БУС РАДИОНАВИГАЦИ	Хөдөлгөөнт бүс, Радионавигацийн үйлчилгээнд ашиглана.
<b>112-115</b> РАДИОНАВИГАЦИ 5.60	<b>112-115</b> РАДИОНАВИГАЦИ	Урт долгионы давтамжинд ажиллах радио навигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>115-117.6</b> РАДИОНАВИГАЦИ 5.60 Хөдөлгөөнт бүс Далайн хөдөлгөөнт 5.64 5.66	<b>115-117.6</b> РАДИОНАВИГАЦИ Хөдөлгөөнт бүс	
<b>117.6-126</b> ХӨДӨЛГӨӨНТ БУС ДАЛАЙН ХӨДӨЛГӨӨНТ РАДИОНАВИГАЦИ 5.60 5.64	<b>117.6-126</b> ХӨДӨЛГӨӨНТ БУС РАДИОНАВИГАЦИ	
<b>126-129</b> РАДИОНАВИГАЦИ 5.60	<b>126-129</b> РАДИОНАВИГАЦИ	Урт долгионы давтамжинд ажиллах радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>129-130</b> ХӨДӨЛГӨӨНТ БУС ДАЛАЙН ХӨДӨЛГӨӨНТ РАДИОНАВИГАЦИ 5.60 5.64	<b>129-130</b> ХӨДӨЛГӨӨНТ БУС РАДИОНАВИГАЦИ	

Радио давтамжийн зурвас: 255-495 кГц

283.5-315 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ ДАЛАЙН РАДИОНАВИГАЦИ (чиглүүлэгч дохио) 5.73	283.5-315 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
315-325 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ Далайн радионавигаци (чиглүүлэгч дохио) 5.73	315-325 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	
325-405 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	325-405 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	
405-415 РАДИОНАВИГАЦИ	405-415 РАДИОНАВИГАЦИ	Урт долгионы давтамжинд ажиллах радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
415-435 ДАЛАЙН ХӨДӨЛГӨӨНТ 5.79 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	415-435 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана
435-472 ДАЛАЙН ХӨДӨЛГӨӨНТ 5.79 Агаарын радионавигаци 5.77 5.82	435-472 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.

Радио давтамжийн зурвас: 2 194-3 230 кГц

2 850-3 025 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R) 5.111, 5.115	2 850-3 025 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
3 025-3 155 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	3 025-3 155 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.

Радио давтамжийн зурвас: 3 230-5 003 кГц

3 400-3 500 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	3 400-3 500 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд хөдөлгөөнт хэлбэрээр ашиглана.
3 800-3 900 ХӨДӨЛГӨӨНТ БУС АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) ГАЗРЫН ХӨДӨЛГӨӨНТ	3 800-3 900 ХӨДӨЛГӨӨНТ БУС АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) ГАЗРЫН ХӨДӨЛГӨӨНТ	Радиолокацийн үйлчилгээнд ашиглаж болно.

3 900-3 950 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) 5.123	3 900-3 950 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Нислэгийн хөдөлгөөнийг зохицуулахад ашиглана.
4 650-4 700 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	4 650-4 700 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
4 700-4 750 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	4 700-4 750 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
4 750-4 850 ХӨДӨЛГӨӨНТ БУС АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) ГАЗРЫН ХӨДӨЛГӨӨНТ, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ 5.113	4 750-4 850 ХӨДӨЛГӨӨНТ БУС АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) ГАЗРЫН ХӨДӨЛГӨӨНТ ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	DRM тоон радиогийн үйлчилгээнд ашиглаж болно.

Радио давтамжийн зурвас: 5 003-7 450 кгц

5 480-5 680 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R) 5.111 5.115	5 480-5 680 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
5 680-5 730 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) 5.111 5.115	5 680-5 730 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
6 525-6 685 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	6 525-6 685 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
6 685-6 765 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	6 685-6 765 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.

Радио давтамжийн зурвас: 7 450-13 360 кгц

8 815-8 965 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	8 815-8 965 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
---------------------------------------	---------------------------------------	--

		ОУИНБ Хавсралт-10 Боть 5, Бүлэг 3
8 965-9 040 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	8 965-9 040 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
10 005-10 100 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)  5.111	10 005-10 100 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
11 175-11 275 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	11 175-11 275 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
11 275-11 400 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	11 275-11 400 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
13 200-13 260 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	13 200-13 260 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
13 260-13 360 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	13 260-13 360 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.

Радио давтамжийн зурвас: 13 360-18 030 кгц

17 900-17 970 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	17 900-17 970 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
17 970-18 030 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	17 970-18 030 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.



Радио давтамжийн зурвас: 18 030-23 350 кГц

21 924-22 000 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	21 924-22 000 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн тогтмол байдал аюулгүй ажиллагаанд зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
---	---	--

Радио давтамжийн зурвас: 47-75.2 МГц

74.8-75.2 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.180 5.181	74.8-75.2 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	5.179 Нэмэлт хуваарилалт: 74.6-74.8 МГц болон 75.2-75.4 МГц зурвасуудыг Монгол улсад зөвхөн газрын нэвтрүүлэх станцуудад агаарын радионавигацийн үйлчилгээнд анхдагч хуваарилалтаар ашиглаж болно. (WRC-12) ОУИНБ Хавсралт-10 Боть 1, Бүлэг 3.1.7.2
---	------------------------------------	--

Радио давтамжийн зурвас: 75.2- 137.175 МГц

ОУЦХБ-ын хуваарилалт	Үндэсний хуваарилалт	Ашиглалт
108-117.975 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.197 5.197A	108-111.975 МГц АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Хавсралт-10 Боть 1, Хэсэг 3.1.3.2 дагуу газардуулах системд
	108.025-117,975 МГц АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Баримт бичиг 9849, Пар 5.2 дагуу GNSS-д ашиглана.
117.975-137 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R) 5.111 5.200 5.201 5.202	111.975-117.975 МГц АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Хавсралт-10 Боть 1, Бүлэг 3.3.2
	121.500 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Аюул ослын үед ашиглана. тусгаарлалтын зурвасыг 121.450-121.550 МГц -ээр тогтооно. (Хавсралт-10 Боть 5, баримт бичиг-9718)
	121.500-122.917 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Аеродромын газрын хөдөлгөөний үед нислэгийн өмнө ашиглах, (нислэгийн өмнөх бэлтгэх ажиллагаа)
	123.100 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718 дагуу системд холбогдох бусад төхөөрөмжүүдтэй холбогдох, аврах ажиллагаанд ашиглах
	123.450 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Агаар-Агаар холбоонд ашиглана (Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718)
	123.700-129.700 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Хавсралт-10 Боть 5 дагуу ашиглана
128.825-132.025 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Бүсчилсэн хэрэглээнд нислэгийг удирлах үйлчилгээнд ашиглах /Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718/	

	5.201-ын дагуу 132-136 МГц-ийн царааг АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) үйлчилгээнд анхдагч хуваарилалтаар ашиглана. (WRC-12)	ОУИНБ Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718
	136.925 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Агаар-газар өгөгдлийн холбооны дохиолол дамжуулах сувагт VDL- ийн нөөцөөр (VHF өгөгдлийн шугам) Горим 4 (Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718)
	136.975 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Агаар-газар өгөгдлийн холбооны дохиолол дамжуулах сувагт VDL- ийн нөөцөөр (VHF өгөгдлийн шугам) Горим 2 (Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718)
	136.500-136.975 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R)	Сувгийн давтамжийн зурвасын өргөнийг зөвхөн 25 кГц-ээр ашиглана. Хавсралт-10 Боть 5, Баримт бичиг-9718

Радио давтамжийн зурвас: 137.175-148 МГц

ОУЦХБ-ын хуваарилалт	Үндэсний хуваарилалт	Ашиглалт
138-143.6 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) 5.210 5.211 5.212 5.214	138-143.6 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	Олон улсын болон үндэсний агаарын тээврийн нислэгийн маршрутаас гадна үйлдэгдэж буй нислэг хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан агаарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.
143.6-143.65 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) САНСАР СУДЛАЛ (сансар-газар) 5.211 5.212 5.214	143.6-143.65 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) САНСАР СУДЛАЛ (сансар-газар)	
143.65-144 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR) 5.210 5.211 5.212 5.214	143.65-144 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (OR)	

Радио давтамжийн зурвас: 220-335.4 МГц

328.6-335.4 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.258 5.259	328.6-335.4 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Хавсралт-10 Боть 1, хэсэг 3.1.5.2 дагуу Ультра богино долгионы давтамжинд ажиллах агаарын радионавигациийн тоног төхөөрөмжинд ашиглана.
---	--------------------------------------	---

Радио давтамжийн зурвас: 890-1 300 МГц

ОУЦХБ-ын хуваарилалт Г бүс	Үндэсний хуваарилалт	Ашиглалт
960-1 164 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ (R) 5.327A	960-1 215 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Хавсралт-10 Боть 1, Бүлэг 3.5 дагуу зайг хэмжих төхөөрөмжид

АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.328 5.328AA	1030 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Баримт бичиг 9684.Хавсралт 10 Бүлэг. IV дагуу радарын нэвтрүүлэгч давтамжаар MSS радар, төхөөрөмжид
	1090 МГц АГААРЫН ХӨДӨЛГӨӨНТ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Баримт бичиг 9684.Хавсралт 10 Боть. IV дагуу Радарын MSS, ADS-B хүлээн авах төхөөрөмжид ашиглана.
1 164-1 215 МГц АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОНАВИГАЦИИ-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (газар - сансар)	1 164-1 215 МГц  АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ баримт бичиг 9849, Бүлэг 5.2 Ультра богино долгионы давтамжинд ажиллах агаарын радионавигациийн тоног төхөөрөмжинд ашиглана. GNSS төхөөрөмжид
1 559-1 610 МГц АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОНАВИГАЦИИ-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (газар - сансар)	1559-1610 МГц  АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	ОУИНБ Хавсралт-10 Боть 1, Бүлэг 3.7 дагуу Агаарын радионавигациийн тоног төхөөрөмжинд ашиглана. 1575.42 МГц-ийн давтамжинд GPS төхөөрөмж ажиллах боломжтой. GNSS төхөөрөмжид мөн ашиглана.

Радио давтамжийн зурвас: 1 300-1 525 МГц

ОУЦХБ-ын хуваарилалт I бүс	Үндэсний хуваарилалт	Ашиглалт
1 300-1 350 РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.337 Радионавигаци-хиймэл дагуул (газар -сансар) 5.149 5.337A	1 300-1 350 РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ Радионавигаци-хиймэл дагуул (газар -сансар)	1215-1350 МГц-ийн давтамжийн зурвасыг агаарын хайлт хийх радарын тоног төхөөрөмжинд ашиглана.  1227.6 МГц-ийн давтамжинд сансраас дэлхий дээрх тухайн байршил тодорхойлогч (GPS) төхөөрөмж ажиллана.

Радио давтамжийн зурвас: 1 525-1 610 МГц

1 559-1 610 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОНАВИГАЦИ-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (сансар - сансар) 5.328B 5.329A 5.341 5.208B	1 559-1 610 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОНАВИГАЦИ-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (газар - сансар)	Агаарын радионавигациийн тоног төхөөрөмжинд ашиглана. 1575.42 МГц-ийн давтамжинд GPS төхөөрөмж ажиллах боломжтой.
---	---	---

Радио давтамжийн зурвас: 2 700-4 800 МГц

2 700-2 900 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.337 Радиолокац 5.423 5.424	2 700-2 900 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ Радиолокац	
---	--	--

<b>2 900-3 100</b> РАДИОНАВИГАЦИ 5.424А РАДИОЛОКАЦИ 5.425 5.426 5.427	<b>2 900-3 100</b> РАДИОНАВИГАЦИ РАДИОЛОКАЦИ	Радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
--	--	---

Радио давтамжийн зурвас: 8 500-10 000 МГц

<b>8 500-8 550</b> РАДИОЛОКАЦИ 5.468 5.469	<b>8 500-8 550</b> РАДИОЛОКАЦИ 5.469	<b>5.469-ын дагуу 8 500-8 750 МГц</b> давтамжийн зурвасыг газрын хөдөлгөөнт болон радионавигацийн үйлчилгээнд анхдагч хуваарилалтаар ашиглаж болно. (WRC-12)
<b>8 650-8 750</b> РАДИОЛОКАЦИ 5.468 5.469	<b>8 650-8 750</b> РАДИОЛОКАЦИ 5.469	
<b>8 750-8 850</b> РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.470 5.471	<b>8 750-8 850</b> РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>8 850-9 000</b> РАДИОЛОКАЦИ ДАЛАЙН РАДИОНАВИГАЦИ 5.472 5.473	<b>8 850-9 000</b> РАДИОЛОКАЦИ	Радиолокацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>9 000-9 200</b> РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.337 5.471 5.473А	<b>9 000-9 200</b> АГААРЫН РАДИОНАВИГАЦИ Радиолокаци	Агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>9 200-9 300</b> ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхтэй) 5.474А 5.474В 5.474С РАДИОЛОКАЦИ ДАЛАЙН РАДИОНАВИГАЦИ 5.472 5.473 5.474 5.474D	<b>9 200-9 300</b> ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхтэй) РАДИОЛОКАЦИ	Радиолокацийн тоног төхөөрөмжинд ашиглана.

Радио давтамжийн зурвас: 11.7-14ГГц

<b>13.25-13.4</b> ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.497 САНСАР СУДЛАЛ (идэвхитэй) 5.498А 5.499	<b>13.25-13.4</b> АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
<b>13.4-13.65</b> ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) ХӨДӨЛГӨӨНТ БУС-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) 5.499А 5.499В РАДИОЛОКАЦИ САНСАР СУДЛАЛ 5.499С 5.499D Стандарт давтамж ба цагийн дохио-хиймэл дагуул (газар- сансар) 5.499 5.499E 5.500 5.501 5.501В	<b>13.4-13.65</b> ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) ХӨДӨЛГӨӨНТ БУС-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) РАДИОЛОКАЦИ САНСАР СУДЛАЛ Стандарт давтамж бай цагийн дохио-хиймэл дагуул (газар- сансар)	Радиолокацийн тоног төхөөрөмжинд ашиглана.

Радио давтамжийн зурвас: 15.4-18.4 ГГц

15.4-15.43 РАДИОЛОКАЦИ 5.511E 5.511F АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	15.4-15.43 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОЛОКАЦИ	Агаарын радионавигацийн үйлчилгээнд (нисэх буудлын радарын төхөөрөмж, радио альтиметр) ашиглана.
15.43-15.63 ХӨДӨЛГӨӨНТ БУС-ХИЙМЭЛ ДАГУУЛ (газар-сансар) 5.511A РАДИОЛОКАЦИ 5.511E 5.511F АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.511C	15.43-15.63 ХӨДӨЛГӨӨНТ БУС-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (газар-сансар) АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Агаарын радионавигацийн үйлчилгээнд (нисэх буудлын радарын төхөөрөмж, радио альтиметр) ашиглана.
15.63-15.7 РАДИОЛОКАЦИ 5.511E 5.511F АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	15.63-15.7 РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	
15.7-16.6 РАДИОЛОКАЦ 5.512 5.513	15.7-16.6 РАДИОЛОКАЦИ	Радиолокацийн тоног төхөөрөмжинд ашиглана.
16.6-17.1 РАДИОЛОКАЦИ Сансар судлал (огторгуй) (сансар-газар) 5.512 5.513	16.6-17.1 РАДИОЛОКАЦИ Сансар судлал (огторгуй) (сансар-газар)	
17.1-17.2 РАДИОЛОКАЦ 5.512 5.513	17.1-17.2 РАДИОЛОКАЦ	
17.2-17.3 ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) РАДИОЛОКАЦИ САНСАР СУДЛАЛ (идэвхитэй) 5.512 5.513 5.513A	17.2-17.3 ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) РАДИОЛОКАЦИ САНСАР СУДЛАЛ (идэвхитэй)	
18.1-18.4 ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ БУС-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) 5.484A 5.516B (газар-сансар) 5.520 5.A15 ХӨДӨЛГӨӨНТ 5.519 5.521	18.1-18.4 ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ БУС-ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (газар-сансар) ХӨДӨЛГӨӨНТ	

--- оОо ---

*"Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага"-ын хавсралт-2*

<b>РАДИО ДАВТАМЖИЙН НӨЛӨӨЛӨЛ ҮҮССЭН ТУХАЙ МАЯГТ</b>	<b>___ ОНЫ __САРЫН __ ӨДӨР</b>
---	--------------------------------

• **Нэвтрүүлэгч станцын хаяг, байршил / Location of transmitter station**

Хот / Аймаг   City/province	Сум / Дүүрэг   Area / District, Зип код / Zip code
-----------------------------	--

• **Нэвтрүүлэгчийн газар зүйн координат / Site coordination**

Уртгар/Longitude /E			Өргөрөг/Latitude /N		
Градус/Degree	Минут/Minute	Секунд/Second	Градус/Degree	Минут/Minute	Секунд/Second

• **Нэвтрүүлэх, хүлээн авах станцын үзүүлэлт / Transmitter, receiver stations details**

Станцын нэр/ Call Sign	Гаралтын чадал (Вт) / Transmitter power (W)	Үйлчлэх хүрээ (км) / Radius of service (km)
Модуляцын төрөл / Type of modulation	Зөөгчийн чадал (Вт) / Carrier power (W)	Идэвхитэй цацаргах чадал (Вт) / EIRP (W)
Хүлээн авах мэдрэмж / Rx Sensitivity	Ашиглах давтамжийн зурвас (МГц) / Available frequency band (MHz)	Зурвасын өргөн (МГц) / Bandwidth (MHz)

• **Антенны үзүүлэлт / Antenna details**

Антенны төрөл / Antenna type	Навчны босоо тэнхлэгийн цацаргалтын өнцөг/ Beam width E	Навчны хэвтээ тэнхлэгийн цацаргалтын өнцөг/ Beam width H	
Антенны далайн түвшнээс дээш өндөр (м) / Antenna height above sea level (m)	Хэвтээ өнцөг (Градус) / Azimuth E(Degree)	Босоо өнцөг (Градус) / Elevation V(Degree)	
Газрын дүвшнээс дээшхи антенны өндөр/Antenna height above ground level (m)	Туйлшрал / Polarization		
	Босоо/Vertical	Хэвтээ/Horizontal	Өсгөлтийн коэффициент (дБи) / Antenna Gain (dBi)
Антенны давтамж / Antenna frequency Доод/ From Дээд / To	Кабелийн урт (м) /Cable length (m)	Кабелийн модел/ Cable Model	Эсэргүүцэл (Ом) / Resistance (Ω)

• **Нөлөөлөл үүссэн тухай / Interference about**

Нөлөөлөл эхэлсэн хугацаа/ Interference start time	Нөлөөлөл дууссан хугацаа/ Interference end time	Нөлөөллийн төрөл / Interference type	Тайлбар / Explanation
Авсан арга хэмжээ/take measures			

--- ооо ---